

БНСУ-Д БОГИНО ХУГАЦААНЫ ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРАГДАХЫГ УРЬЖ БАЙНА.

Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хамтын ажиллагааны хүрээнд БНСУ-ын Эрүүл мэндийн байгууллагад богино хугацааны сургалтын тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдахыг урьж байна.

Сургалтын чиглэл:

- **Ерөнхий мэс засал /** Бүдүүн шулуун гэдэсний мэс засал. Элэг, цөс, нойр булчирхайн мэс засал. Хөх, дотоод шүүрлийн мэс засал / – 2
- **Мэдрэлийн мэс засал – 1**
- **Эмэгтэйчүүдийн өвчин судлал – 1**
- **Урологи – 1**

Сургалтын хугацаа: Сургалт 21 хоног үргэлжлэх ба 2023 оны 5-6 сард сургалтад хамрагдана.

Тавигдах шаардлага

1. Төрийн өмчийн эрүүл мэндийн байгууллагад ажилладаг байх;
2. Тухайн чиглэлээр үндсэн болон төрөлжсөн мэргэшил эзэмшсэн байх;
3. Эзэмшсэн мэргэшлээрээ тухайн байгууллагадаа 3-аас доошгүй жил тогтвор суурьшилтай ажилласан байх;
4. Англи хэлний ахисан түвшний мэдлэгтэй байх;
5. Өөрийн мэргэшсэн чиглэлээрээ суралцаж амжилт гаргах хүсэл эрмэлзэлтэй байх;

Бүрдүүлэх материал

1. CV буюу хувь хүний дэлгэрэнгүй тодорхойлолт [/татаж авах/](#) /Одоо хэрэглэж буй утасны дугаарыг заавал оруулах/;
2. Англи хэлний түвшин тогтоох шалгалтын оноо, гэрчилгээний хуулбар /БНСУ дахь эрүүл мэндийн байгууллагаас Англи хэлээр ярилцлага авна/;
3. Эрүүл мэндийн ажилтны нэгдсэн бүртгэлийн санд [/ www.hr.hdc.gov.mn/](http://www.hr.hdc.gov.mn/) бүртгэлтэй байх;

Холбогдох материалыг 2023 оны 05 дугаар сарын 09-ний 18:00 цаг хүртэл sumunkhdelger@gmail.com хаягаар хүлээн авна.

Лавлах утас: 98142485